



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/283

Хэрлэн сум

“Призм” продакшнд  
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны хүүхэд, хөгжил, хамгааллын жил болгон зарласантай холбогдуулан хүүхдийн баярыг угтан хүүхэд багачуудад зориулсан “Призм” продакшний бүтээл “Зүггүй Шөмбөөлэй” хүүхдийн жүжиг тайзнаа туурвихад шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

05 Аймгийн Засаг даргын 2022 оны  
А/282 дугаар сарын 25-ны өдрийн  
захирамжийн хавсралт

Зарцуулах хөрөнгийн төсөв тооцоо

№	Нэр	Нэгж үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Ишигний хувцас	98300	1	98300
2	Хурганы хувцас	98300	1	98300
3	Тугалны хувцас	98300	1	98300
4	Нохойны хувцас	98300	1	98300
5	Тахианы хувцас	98300	1	98300
6	Араатны хувцас, баг	60000	1	60000
7	Бүжигчин хурганы хувцас	73500	5	367500
8	Бүжигчин тугалны хувцас	73500	5	365000
9	Жижиг хэрэглэл	40000	5	200000
10	Театрын нүүрний будаг	50000	3	150000
11	Тайзны ерөнхий зураг	300000	1	300000
12	Тайзны мод	150000	2	300000
13	Тайзны хад чулуу	86000	2	86000
14	Тайзны хашаа	80000	2	80000
15	Хувцас, тайзны скиз	300000		300000
16	Оёдолчны хөлс	300000		300000
<b>Нийт</b>				<b>3,000,000</b>